

БАТЛАВ
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН БАГАНУУРЫН ГАЗРЫН ДАРГА



.....Х.ПҮРЭВСҮРЭН

БАТЛАВ
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН
ДАРГА



.....Ч.ЭЛБЭГСАЙХАН

АВТО ГРАЖИД МАШИН БАЙРЛУУЛАХ ГЭРЭЭ

2019 оны 06-р сарын 28

№ *БР/АГ/19-01*

Багануур дүүрэг

Нэг. Гэрээний талууд

- 1.1 Нэг талаас: **Багануур Үйлдвэрлэл технологийн парк** /цаашид “Түрээслэгч” гэх/
- 1.2 Нөгөө талаас: “МХС” ХХК-ийн Багануур дүүргийн газар /цаашид “Түрээслүүлэгч” гэх/ талууд хамтран ажиллахаар харилцан тохиролцож доорхи гэрээг байгуулав.

Хоёр. Гэрээний ерөнхий нөхцөл

- 2.1 Энэхүү гэрээний зорилго нь “Түрээслүүлэгч” нь өөрийн эзэмшлийн гражид “түрээслэгч” -н машин байрлуулах, төлбөр тооцоог барагдуулахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 2.2 Энэхүү гэрээ нь 2019 оны 07-р сарын 01-ны өдрөөс 2020 оны 07-р сарын 01-ны өдөр хүртэл хугацаанд үйлчилнэ.
- 2.3 “Түрээслэгч” нь түрээслүүлэгчийн эзэмшлийн гражид машин байрлуулах, төлбөр тооцоог барагдуулах.

Гурав. Түрээсийн төлбөр, түүнийг төлөх

- 3.1 Машин байрлуулах түрээсийн төлбөр нь хоногийн 2000 төгрөг байна.
- 3.2 “Түрээслэгч” нь түрээсийн төлбөрийг сар бүр хуанли хоногийн тоогоор тооцож төлнө.

Дөрөв. Талуудын эрх үүрэг

- 4.1 “Түрээслүүлэгч” -ийн эдлэх эрх
 - 4.1.1 Түрээсийн төлбөрийг энэ гэрээний 3-т заасны дагуу төлөхийг шаардах.
 - 4.1.2 “Түрээслэгч” гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой буюу удаа дараа зөрчсөн, төлбөрийн чадваргүй болсон нь илэрсэн тохиолдолд энэ гэрээний 5-р зүйлд заасны дагуу гэрээг цуцлахыг шаардах.
 - 4.1.3 Хуульд заасан бусад эрх эдэлнэ.
- 4.2 “Түрээслүүлэгч” -ийн хүлээх үүрэг
 - 4.2.1 Галын аюулгүй байдлыг харуул жижүүрүүд хийх бөгөөд дэвтэрт тэмдэглэн хүлээлцэнэ.
 - 4.2.2 Гражид автомашиныг байрлуулахдаа хоорондын зай ГАБ-ыг хангана.
- 4.3 “Түрээслэгч” -ийн хүлээх үүрэг

- 4.3.1 Түрээсийн төлбөрийг гэрээнд тогтоосон хугацаанд сааталгүй төлнө.
- 4.3.2 Ашиглалтын явцад өөрийн буруугаас эвдрэл гэмтэл учруулбал хохирлыг хариуцан арилгана
- 4.3.3 Автогражид бензин тос асгах, шатах материал хадгалах цэвэрлэгээ хийхийг хориглоно.
- 4.3.4 Тамхи татах, ил гал гаргах, шүдэнз зурахыг хориглоно
- 4.3.5 Автомашиныг ил гал, дөлөөр бардах гэсгээхийг хориглоно.
- 4.3.6 Түрээслэгчид гал ус, гамшигийн үед ажиллах дэгийг мөрдөж ажиллах.

Тав. Гэрээг өөрчлөх, цуцлах, сунгах

- 5.1 Энэхүү гэрээнд гагцхүү Талуудын харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр хийсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулах бөгөөд эх хувьд баллаж засварласан буюу бусад аргаар оруулсан аливаа нэмэлт бичилтийг хүчингүйд тооцно.
- 5.2 Хоёр талын аль нэг нь энэ гэрээг хугацаанаас өмнө цуцлахыг хүсвэл энэ тухайгаа нэг сараас доошгүй хугацааны өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэх ба уг хугацаа болмогц энэ гэрээг цуцласанд тооцно.

Зургаа. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

- 6.1 "Түрээслэгч" түрээсийн төлбөрийг сар бүрийн 20-ны дотор төлнө. Тогтоосон хугацаанаас өмнө төлөөгүй бол хэтэрсэн хоног тутам төлбөрийн 10 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг "Түрээслүүлэгч"-д төлнө.
- 6.2 "Түрээслүүлэгч" нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд 1 сар хүртлэх хэмжээний төлбөртэй тэнцэх хэмжээний торгууль хүлээнэ.
- 6.3 Гэрээ болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой маргаан гарвал Талууд хэлэлцээний журмаар шийдвэрлэнэ. Хэрэв үр дүнд хүрэхгүй бол маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Долоо. Бусад



- 7.1 Энэхүү гэрээг 2 хувь үйлдэх ба талууд нэг нэг хувь хадгална.
- 7.2 Гэрээ нь талууд гарын үсэг зурсанаар хүчин төгөлдөр болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

"Түрээслүүлэгч"-ийг төлөөлж:
"МХС" ХХК-ийн Багануурын газрын
Дамжуулах байгууламжийн инженер
.....
Б.Оргил
Харилцах данс:
Хаан банк 5750755268

Утас: 7021-2178

"Түрээслэгч"-ийг төлөөлж:

1.  

Утас: 70213292